



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/35/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт хот

2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369      Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123      Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:              Б.Ганцэцэг

Утас: 70512127      Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Албан шаардлага .....	15
4.2 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар

## Аудитын санал дүгнэлт



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518398  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 67  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ  
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА О.БАТНАСАН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Дарьганга сумын ойн зурвас байгуулах 5.0 сая төгрөгийн ажлыг 2022 онд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, шууд зардалд илэрхийлэн, төсвийн гүйцэтгэлийг илүү тайлагнасан, бараа материалын тайланд бүртгэлтэй хөрөнгө бодитоор байхгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг ил тод байршуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Н.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>12,850,490.00</u></b>	<b><u>17,464,120.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,000,000.00	5,000,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,000,000.00	5,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,000,000.00	5,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,850,490.00	12,464,120.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,250,490.00	11,864,120.00
35410	Бичиг хэргийн материал	2,480,000.00	2,674,450.00
35420	Аж ахуйн материал	1,257,490.00	2,325,790.00
35470	Бусад хангамжийн материал	7,513,000.00	6,863,880.00
35600	Мал амьтад	600,000.00	600,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>345,813,721.30</u></b>	<b><u>330,727,014.27</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	345,813,721.30	330,727,014.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	193,397,721.30	178,311,014.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,611,936.00	18,611,936.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,545,758.10	-2,768,220.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	105,173,630.00	96,679,960.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,481,443.94	-30,967,767.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,437,403.00	67,548,536.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,997,436.62	-35,088,103.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,353,175.00	15,063,195.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,260,304.95	-3,521,514.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,820,785.00	62,820,785.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,714,264.09	-10,067,792.37
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	152,416,000.00	152,416,000.00
39301	Програм хангамж	970,000.00	970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-970,000.00	-970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	152,416,000.00	152,416,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>358,664,211.30</u></b>	<b><u>348,191,134.27</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,000,000.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,000,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,000,000.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,000,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,000,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>357,664,211.30</u></b>	<b><u>348,191,134.27</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	357,664,211.30	348,191,134.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	161,183,515.00	161,183,515.00
51101	Өмч: - төрийн	161,183,515.00	161,183,515.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	196,348,832.30	186,875,755.27
51210	Өмнөх үеийн үр дүн	196,348,832.30	196,348,832.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,473,077.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,864.00	131,864.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>358,664,211.30</u></b>	<b><u>348,191,134.27</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>789,577,236.00</b>	<b>715,161,358.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>145,370,636.00</b>	<b>431,958.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	145,370,636.00	431,958.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,370,636.00	364,406.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	364,406.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	145,370,636.00	00.00
120009	Бусад орлого	00.00	67,552.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>644,206,600.00</b>	<b>714,729,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	58,726,700.00	130,703,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,471,170.00	7,343,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	119,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,255,530.00	4,360,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	585,479,900.00	584,026,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,479,900.00	584,026,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>610,784,016.41</b>	<b>724,634,435.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>610,784,016.41</b>	<b>724,634,435.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	580,245,467.56	704,614,319.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	292,242,204.25	301,425,142.44
210101	Үндсэн цалин	231,204,163.75	223,919,715.11
210102	Нэмэгдэл	51,869,917.58	48,631,094.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,168,122.92	9,655,458.24
210104	Урамшуулал	00.00	19,218,874.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,208,621.90	38,715,114.62
210201	Тэтгэврийн даатгал	24,744,277.40	27,041,488.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,911,090.34	3,014,251.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,328,873.07	2,411,400.96
210204	Ажилгүйдлийн даатгал	565,853.78	567,998.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,658,527.31	5,679,975.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,342,229.00	8,954,007.00
210301	Гэрэл, цахилгаан	281,639.00	185,334.00
210302	Түлш, халаалт	7,358,890.00	7,813,693.00
210303	Цэвэр, бохир ус	701,700.00	679,980.00
210304	Байрны түрээс	00.00	275,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,164,271.00	12,676,200.00
210401	Бичиг хэрэг	2,856,861.00	2,319,600.00
210402	Тээвэр, шатахуун	7,017,964.00	7,178,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,704,726.00	1,321,971.00

**Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	584,720.00	1,856,109.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>515,923.00</b>	<b>3,862,488.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	365,923.00	3,562,488.00
210604	Урсгал засвар	150,000.00	300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,820,000.00</b>	<b>4,132,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,820,000.00	4,132,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,208,559.00</b>	<b>21,907,467.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,553,609.00	21,150,632.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,050.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,900.00	115,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	291,810.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>224,743,659.41</b>	<b>312,941,500.03</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,989,918.00	282,514,993.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	320,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,533,741.41	30,106,507.03
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,538,548.85</b>	<b>20,020,115.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,206,200.00</b>	<b>5,429,415.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,986,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,220,000.00	5,429,415.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,332,348.85</b>	<b>14,590,700.94</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,332,348.85	14,590,700.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>178,793,219.59</u></b>	<b><u>-9,473,077.03</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>178,793,219.59</u></b>	<b><u>-9,473,077.03</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дун	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	93,094,515.00	1,703,523.00	-47,717,113.27	00.00	47,080,924.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	00.00	00.00	1,703,523.00	00.00	1,703,523.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>93,094,515.00</b>	<b>1,703,523.00</b>	<b>-46,013,590.27</b>	<b>00.00</b>	<b>48,784,447.73</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	68,089,000.00	00.00	-18,689,133.41	00.00	49,399,866.59
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>161,183,515.00</b>	<b>131,864.00</b>	<b>196,348,832.30</b>	<b>00.00</b>	<b>357,664,211.30</b>
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>161,183,515.00</b>	<b>131,864.00</b>	<b>196,348,832.30</b>	<b>00.00</b>	<b>357,664,211.30</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>161,183,515.00</b>	<b>131,864.00</b>	<b>196,348,832.30</b>	<b>00.00</b>	<b>357,664,211.30</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,473,077.03	00.00	-9,473,077.03
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>161,183,515.00</b>	<b>131,864.00</b>	<b>186,875,755.27</b>	<b>00.00</b>	<b>348,191,134.27</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН</b>	<b><u>656,258,600.00</u></b>	<b><u>716,161,358.00</u></b>

	ДҮН (1)		
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>431,958.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	431,958.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	364,406.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	364,406.00
120009	Бусад орлого	00.00	67,552.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>656,258,600.00</b>	<b>715,729,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	70,778,700.00	131,703,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,471,170.00	7,343,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,052,000.00	120,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,255,530.00	4,360,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	585,479,900.00	584,026,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	585,479,900.00	584,026,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>600,546,965.00</b>	<b>701,141,558.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>600,546,965.00</b>	<b>701,141,558.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>570,008,416.15</b>	<b>680,121,442.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	292,342,204.25	301,425,142.44
210101	Үндсэн цалин	231,265,625.75	223,919,715.11
210102	Нэмэгдэл	51,908,455.58	48,631,094.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,168,122.92	9,655,458.24
210104	Урамшуулал	00.00	19,218,874.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,208,621.90	38,715,114.62
210201	Тэтгэврийн даатгал	24,744,277.40	27,041,488.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,911,090.34	3,014,251.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,328,873.07	2,411,400.96
210204	Ажилгүйдлийн даатгал	565,853.78	567,998.59
210205	Эрүүл мэндийн даатгал	5,658,527.31	5,679,975.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,311,529.00	8,954,007.00
210301	Гэрэл, цахилгаан	281,639.00	185,334.00
210302	Түлш, халаалт	7,358,890.00	7,813,693.00
210303	Цэвэр, бохир ус	671,000.00	679,980.00
210304	Байрны түрээс	00.00	275,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,598,889.00	13,721,530.00
210401	Бичиг хэрэг	3,079,481.00	2,904,930.00
210402	Тээвэр, шатахуун	11,119,408.00	7,178,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,459,471.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	2,178,609.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,010,633.00	5,776,488.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	860,633.00	5,476,488.00
210604	Урсгал засвар	150,000.00	300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,820,000.00	4,132,400.00
210702	Дотоод албан томилолт	2,820,000.00	4,132,400.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,278,259.00	22,536,467.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,623,309.00	21,757,632.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,050.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,900.00	115,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	00.00	291,810.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	209,438,280.00	284,860,293.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	209,218,280.00	284,540,293.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,538,548.85</b>	<b>21,020,115.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,206,200.00	6,429,415.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,986,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,220,000.00	6,429,415.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	7,332,348.85	14,590,700.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,332,348.85	14,590,700.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>55,711,635.00</u></b>	<b><u>15,019,800.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>55,711,635.00</u></b>	<b><u>15,019,800.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>55,711,635.00</u></b>	<b><u>15,019,800.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	55,711,635.00	15,019,800.00
223001	Бусад хөрөнгө	9,800,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,911,635.00	15,019,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-55,711,635.00</u></b>	<b><u>-15,019,800.00</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	634,188,200.00	571,063,209.06
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	634,188,200.00	571,063,209.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	628,688,200.00	565,633,794.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	307,532,400.00	301,425,142.44
210101	Үндсэн цалин	225,600,000.00	223,919,715.11
210102	Нэмэгдэл	51,600,000.00	48,631,094.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,832,400.00	9,655,458.24
210104	Урамшуулал	20,500,000.00	19,218,874.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,516,900.00	38,715,114.62
210201	Тэтгэврийн даатгал	29,215,600.00	27,041,488.16
210202	Тэтгэмжийн даатгал	3,075,300.00	3,014,251.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,460,300.00	2,411,400.96

210204	Ажилгүйдлийн даатгал	615,100.00	567,998.59
210205	Эрүүл мэндийн даатгал	6,150,600.00	5,679,975.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,199,000.00</b>	<b>8,954,007.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	250,000.00	185,334.00
210302	Түлш, халаалт	8,714,000.00	7,813,693.00
210303	Цэвэр, бохир ус	960,000.00	679,980.00
210304	Байрны түрээс	275,000.00	275,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,205,000.00</b>	<b>10,203,620.00</b>
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,499,930.00
210402	Тээвэр, шатахуун	4,705,000.00	4,703,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,460,000.00	1,459,471.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,540,000.00	1,540,699.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,091,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	791,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,100,000.00</b>	<b>2,082,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,100,000.00	2,082,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,406,600.00</b>	<b>3,390,067.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,625,800.00	2,611,232.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,900.00	115,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	292,900.00	291,810.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>252,628,300.00</b>	<b>199,771,943.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	252,308,300.00	199,451,943.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320,000.00	320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,500,000.00</b>	<b>5,429,415.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,500,000.00</b>	<b>5,429,415.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	5,429,415.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>634,188,200.00</b>	<b>571,063,209.06</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>634,188,200.00</b>	<b>571,063,209.06</b>
132001	Орон нутгийн төсвөөс	634,188,200.00	571,063,209.06
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>27.00</b>	<b>27.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>27.00</b>	<b>27.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22.00	22.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>130,507,448.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>130,507,448.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>129,507,448.00</b>

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,517,910.00
210401	Бичиг хэрэг	405,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,475,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	637,910.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,484,988.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,484,988.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,050,000.00
210702	Дотоод албан томилолт	2,050,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,146,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,146,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	99308150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,308,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1000000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	130507448.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	130,507,448.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,343,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,875,038.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,289,410.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Байгууллагын зорилго: Байгальд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, иргэд, байгууллагыг салбарын чиг үүрэг, удирдлага арга зүйгээр хангахад оршино.

Зорилтууд:

- Байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, бодлогын уялдааг сайжруулж, экологийн баримжаатай нийгэм, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинтой холбоотой мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгож, байгаль хамгаалахад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

Чиг үүрэг: Аймгийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн А/18 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар БОАЖГ-ын ажилтнуудын чиг үүргийг тодорхой зааж өгчээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БОАЖГ-ын даргын 2020.02.18 өдрийн А/07 тоот тушаалаар дотоод хяналт, шалгалт хийх ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон. Уг дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь ЗГ-ын "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах тухай" 311-р тогтоол, Мөн ЗГ-ын 206-р тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны А/343 тоот захирамжийг үндэслэн хяналт шалгалтыг хагас, бүтэн жилээр зохион байгуулдаг.

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9-р хавсралт "Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт"-ийн дагуу 5 үзүүлэлтээр дүгнэж хэрэгжилтийн дундаж 98.9 хувиар үнэлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 610.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 4.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.4 сая төгрөг буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөг, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1	5	4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Бараа материал	11.8	12.5	0.7
Үндсэн хөрөнгө	345.80	330.70	-15.10
Нийт хөрөнгө	<b>358.60</b>	<b>348.20</b>	<b>-10.40</b>
Өр төлбөр	1	0	-1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	357.60	348.20	-9.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<b>358.60</b>	<b>348.20</b>	<b>-10.40</b>

Авлага дансны үлдэгдэл 5.0 сая төгрөгөөр өссөн нь “Сүхбаатар-ойжуулалт” сум дундын ойн ангитай “Ойн зурвас байгуулах ажлын гэрээ”-г 2022 онд хийгдэхээр урьдчилж төлбөр төлсөн нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.5 сая төгрөг болж, 0.7 сая төгрөгөөр өссөн нь шинэ байранд орсонтой холбоотой хаалга, хөшиг зэрэг аж ахуйн материал худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансанд нийт 10 нэр төрлийн 15.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 06 сарын 08-ны өдрийн 37 дугаар тогтоолоор 23 нэр төрлийн 39.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 30.1 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 348.2 сая төгрөг болж 9.4 сая төгрөгөөр буурсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 74.2 сая төгрөг буюу 9.4 хувиар буурсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого 72.2 сая төгрөгөөр нэмэгдсэн бол орон нутгийн төсвөөс санхүүжих 1.4 сая, туслах үйл ажиллагааны орлого 144.9 сая төгрөгөөр буурсан тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 119.1 сая төгрөг буюу 19.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь багаж хэрэгсэл, дотоод томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 424.5 сая, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 280.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал үйл ажиллагааны зардал 42.9 сая төгрөгөөр буурч 381.6 сая төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 28.0 сая төгрөгөөр буурч 252.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээнд улсын төсвөөс 634.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 571.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 50.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгож, 14.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн засаг даргын захирамжаар 119.3, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 7.3, туслах үйл ажиллагааны орлогоос 4.3, бусад орлого 0.4, нийт 131.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс дэлхийн байгаль хамгаалах сангаас Аймгийн хэмжээнд зохион байгуулсан сургалтад 7.3, гэр хорооллын эко жорлонгийн тоог нэмэгдүүлэх ажилд 19.0, “Хоггүй цэвэрхэн монгол” аяны хүрээнд аймгийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлын хүрээнд 11.0, аймгийн төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд 39.2, ногоон байгууламжид шинээр тарих модны нүх ухах, хөрс татах, мод суулгац худалдан авах ажилд 50.0, байгууллагын тохижилтод 4.0, нийт 130.5 сая төгрөгийг зарцуулж, 1.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Аймгийн засаг даргатай гүйцэтгэлийн гэрээ байгуулж 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.0 хувийн биелэлттэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 9.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 0 төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 198 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 9.1 сая төгрөгийг эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулж, урьдчилан шилжүүлснийг буцаан төвлөрүүлсэн;
- Асгат сумын байгаль хамгаалагч Д.Ариунаад удаан жилийн нэмэгдлийг илүү олгосон 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлүүлсэн;
- Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна;

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.6 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 5.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 0.6 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### 4.1 Албан шаардлага

- *Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тайлант онд хийгдэхээр төлөвлөгдсөн ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах, ойн зурвас байгуулах 5.0 сая төгрөгийн ажлыг 2022 онд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, шууд зардалд илэрхийлж, төсвийн гүйцэтгэлийг илүү тайлагнасан зөрчил илэрлээ.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>1</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>2</sup>-т заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо. Энэ нь санхүүгийн тайлангийн болон ажил гүйлгээний иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх

<sup>1</sup> Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ;

<sup>2</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

өртөггүй 26 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

**2. Бараа материалын тайлантай холбоотой асуудал**

**Илрүүлэлт**

Бараа материалын тайланд 0.6 сая төгрөгийн дансны үнэтэй 2 морь бүртгэгдсэн боловч бодитоор байхгүй байна.

**Өгсөн зөвлөмж**

Бодитоор байхгүй 2 морины асуудлын эзэн холбогдогчийг тогтоон, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж данс бүртгэлээс хасах;

**3. Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 874.8 сая төгрөгийн 45 мэдээллийг ил тод байршуулахаас 681.4 сая төгрөгийн 29 мэдээллийг ил тод байршуулаагүй, байгаа мэдээллийг байхгүйгээр мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	4	5.6					1	5.0	3	0.6